



**MONGOLIAN A1 – HIGHER LEVEL – PAPER 1**  
**MONGOL A1 – NIVEAU SUPÉRIEUR – ÉPREUVE 1**  
**MONGOL A1 – NIVEL SUPERIOR – PRUEBA 1**

Thursday 13 May 2010 (afternoon)  
Jeudi 13 mai 2010 (après-midi)  
Jueves 13 de mayo de 2010 (tarde)

2 hours / 2 heures / 2 horas

---

INSTRUCTIONS TO CANDIDATES

- Do not open this examination paper until instructed to do so.
- Write a commentary on one passage only.

INSTRUCTIONS DESTINÉES AUX CANDIDATS

- N'ouvrez pas cette épreuve avant d'y être autorisé(e).
- Rédigez un commentaire sur un seul des passages.

INSTRUCCIONES PARA LOS ALUMNOS

- No abra esta prueba hasta que se lo autoricen.
- Escriba un comentario sobre un solo fragmento.

Доорх хоёр зохиолын **аль нэгийг** сонгон тайлбарлаж бич.

1.

5 Өэлүн үжин өнгийн цэцэг өвсийг сонирхож явтал гэнэт хэвлий нь өвдөн үүсгэвээ. Бие жирэмсэн тул өдөр хоногийг тоолж үзвэл чивхийтэл арван сар дүүрч, хөнгөжих цаг болсон байлаа. Өэлүн үжин хэдий бээр анх нярайлахыг завдан буй боловч хэвлий өвдөх байдлаас, харьж амжихгүйгээ мэдээд, яаран далд нөмөр газрыг эрж очин хөнгөжив. Тэр үед Дэлүүн Болдог уулын оройгоос хэдэн тэвэр бүдүүн цагаан гэрэл мандан гарч, солонго мэт тэнгэрийн цээлд тулав аа. Онон мөрний ус ёроолдоо хүртэл тув тунгалаг болж, хэдэн алдын их загас цөм үзэгдэв. Энэ хүүхдийн мэндэлсэн цаг нь хар морин жилийн дөрвөн сарын арван зургааны морин цаг байлаа. Өэлүн үжин арван есөн настай, 10 Есүхэй баатар хорин таван настай байлаа.

Тэндээс Өэлүн үжин ууган хүүхдээ зүлэг өвсөн дээр хөнгөлөөд хүйс огтлох зэв үгүй тул үе цагаан өвсөөр хүйсийг боож, дагалт эхнэр охидоор хадны ирт чулууг авчруулж, хүйсийг зандчин таслав. Үүнд Өэлүн үжиний дотор уярч, нүдний нулимс хүүхдийн хүйс ба чулуу, өвсөнд сувдран дусаллаа. Өэлүн үжин:

15 *Аяа ууланд төрсөн анх нялх минь  
Өвсөнд ургасан эрдэнэ хүү минь  
Ач чинь өл цагаан өвс адил олон болтугай  
Хаан угсаа чинь хад чулуу адил бат болтугай*

гэж чин үнэнээр зөгнөн ерөөлөө. 20 Нялх хүүхдийг хадны булгийн усаар угаахад хоёр гартаан хонины шагайн чинээ хоёр хэсэг нөж атгаад төрсөн байв. Бүгдээр их л гайхалдан сонирхож байтал дагалт охид хэдүйн хороондоо гүйн хүрч эсгий бүрээстэй тэрэг авчрав. Төдөлгүй Өэлүн үжин хийгээд нялх хүүхдийг тэргэн дээр суулган харьж ирэх замд урианхай аймгийн нүдэрмэгч шинжигч Жарчуудай өвгөн учрав. Энэ өдөр 25 Жарчуудай өвгөн гурван настай хүү Зэлмээн тэврэн, Балгуу хороонд (хүрээнд ред) ирж яваад Дэлүүн болдог уулын оройгоос цагаан гэрэл гарсныг олж үзэн, гэрлийг олж үзэхээр очихдоо Өэлүн үжинд ийн золгосон ажээ. Жарчуудай нялх хүүхдийг шинжиж үзээд “Өө, үнэн тэнгэрийн хөвгүүн энд байх ажээ” гэж дуу алдав. Жарчуудай, Өэлүн үжинийг дагаж Балгуу хороонд хүрч, “Энэ хүүхэд 30 ертөнцийн хүмүүний шим бус, ерийн хүмүүнтэй үлтгэж (адил) ширээ ба хөсөрт хэвтүүлэн тэжээж болохгүй. Эрхбиш хий агаарт хөндий тэжээвэл сая бузар буртаг халдахгүй” гэлээ. Өөлүн үжин хэрхэн хий агаарт хөндий агаарт байлган тэжээх вэ гэж асуусанд, Жарчуудай баахан бодоод: “Энэ хялбар аа. Талын бургасны бүдүүнийг нь аргалын галд нугалж, арал болгон нарийнийг нь 35 мурийлган доор нь ялуу хийж, сайхныг нь гөрж гархи болгон толгойг нь халхлан зуны чийгт өлгөж тэжээ. Өвлийн хүйтэнд өвөрлөж хөхүүл. Үүний нэрийг үлэмж буянтныг тэжээх тул <<Өлгий>> гэж, маш буянтныг тэжээх тул <<манцуй>> гэж нэрлэе гэвээ. Тэр хэлсэн ёсоор өлгий хийж гурав хоноод, нялх хүүхдийг өврөөс гарган, есөн булгийн усаар тахин угааж, есөн гүүний сүүгээр 40 сүрчиж, өлгийд оруулав. Жарчуудай тос, тараг, зөөхийгөөр өлгийг мялааж:

*Тэгш сайхан өлгийд хэвтсэнээр  
Тэнгэрийн үрст тэмцэл үл халдтугай!  
Бургас модны өлгийд хэвтсэнээр  
Богдын үрст буртаг үл хүртүгэй!* 45 *Хас сайхан өлгийд хэвтсэнээр хан хөвгүүн чи*

*Хамгийг эзлэгч хаан сууж олныг амгуултугай!  
Дээд хөндий өлгийд хөвтсэнээр дэлгэрэгч богд чи  
Дэлхийг эзлэгч эзэн болж нийтийг жаргуултугай!*

50 гэж билэгдэн ерөөлөө. Жарчуудай бас Зэлмэ хүүгээ үлдээн өгч, хойчийн өдөр сайд түшмэл болог гэсэнд Өэлүн үжин "Арайхан бяцхан байна, өөлий болсон хойно өгч тэтгүүлтүгэй" гээд хурим хийж дайлан, хүнд бэлэг шагнаж хариуллаа.

55 Тэр цагт Есүхэй баатар татаар аймгийг их л дайлан, Тэрмийг амьдаар нь бариад замдаа бас Тэмээчин аймгийг олзолж, Балгуу хороондоо эргэж ирэх ууган хүүгийн сар дүүрэхэд тохиолдов. Есүхэй баатар хүүг үзвэл цагаан тараг цогцолсон мэт гэрэлтэй, шар тос царцсан мэт шимтэй, толгой их, нүүр дөрвөлжин, сүр жавхаатай бөгөөд гүн шинжтэй.

60 Есүхэй баатар тэсгэлгүй баярлан: "Энэ хүүг төрөхөд би дайснаа дарав. Энэ бас нөж атгаж төрсөн нь хойч өдөр лав нэгэн сонин гайхамшигт их эр гарна бизээ. Татаарыг дараад, Тэмээчнийг олзолсон тэнгэрийн бэлгэт тохиолдов" гэж нэрийг Тэмүүжин гэж өгөв өө.

*В.Инжинаши "Хөх судар" роман, 1991 он, Улаанбаатар хот*

2.

- ...Авах гээхийн орныг мэдэлгүй хэвтэж  
Алцалцаж явснаа бузгай хэмээн бодогч  
Аль айхтар загнагч хувилгаан нэрт чи  
Алсдаа хойдох үхлээс давахгүй бөгөөс
- 5 Амархан аашилж загнахаа цэглэвээс хэрэгтэй еэ.  
Нойрмог согтуу явдлаа гэмд үзэхгүй байж  
Номыг хийсэн төрөлхтнийг элэглэх бид нь олон биш үү?  
Нохойгоо зодох хүнээс өмөөрөх байтал  
Номын богд лам нараа үл хайрлах юун.
- 10 Өлөлзөн сэртэлзээч ховдог зан аашаар  
Өл овоо мэт олзны замыг сахивч  
Өнөөх өөрийн чинь бэлдэж тавьсан үйл тэр чинь  
Өөд нэрийг чинь харуулна гэж үү? Арай бэрх буй за.  
Бусдын явдлыг аргыг нь бартал сонжилдог сэтгэл чинь
- 15 Буянт мөрөөс агзайдаг энэ зан чинь юун билээ.  
Бух мэт тэнэгүүдийг хуурдаг эрэмшлээр  
Бултаад бултаад үйлээс дутааж үл болох буй.  
Үл загнах элдэв зангаар энэ мэт байхдаа  
Үеийн нөхрөөс эхлээд аав ээжийгээ хүртэл
- 20 Үнэн худлаар аяыг нь үзэж хуурдаг чамайг үхэхийн цагт  
Үхрийн ходоод гэдэг үлгэр арайхан болшгүй биш үү?  
Адаг зэрэг нь дэлхий дээр мөр мөртөө байсан  
Аргал ус шарилж цулхир бог өвснүүдийг  
Арван хурууны махыг тасдаж өгөх адил
- 25 Араа шүдээ зууж ярвайж юунд харамнадаг буй.  
Ариун сэтгэлийн ач ба аав ээжийн өлзий хишиг  
Алс эртний үйлээр заяандаа болом за.  
Арилжаа худалдаанд шунан арьс махаа туртал  
Амархан унтаж чадахгүй бодол болдог нь юу вэ?
- 30 Ай хайрхан Манзушири минь! гэж эзэндээ сүсэглэдэг зан чинь харин  
Алба татварын цагт цухалддаг биш үү. ...

*Д.Равжаа “Наадмын шүлэг”, Ц.Дамдинсүрэн “Монгол уран зохиолын дээж зуун билиг оршивой” 1956 номоос*